

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр	9
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12.	Шилэн дансны мэдээлэл	10
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүү байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
	Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан	20
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
САГ	Санхүүгийн аудитын газар
ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТУН	Төслийн удирдах нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН
УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
С.ЗАНДАНБАЛ ТАНАА

2020.03.24 № 06/923
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөлд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төслийн зохицуулагч С.Занданбал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой валютын ханшийн зөрүүгийн олзыг бүртгэх, үндсэн хөрөнгийг ангилалын дагуу зөв бүртгэх, татварын тооцоог тухай бүр хийж тайлан тооцоонд тусгаж байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс, 2020 оны 3 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Сүлд-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт ирүүлээгүй, Сүлд-Аудит ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 26/20 дугаар албан тоотоор хүргүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн гол зорилго нь төсөлд хамрагдсан аймаг, сумдын малчин өрхүүд болон сумын төвийн иргэдийн ядуурлыг бууруулж амьжиргааг дээшлүүлэх явдал юм.

Тус төслийн үйл ажиллагааны чиглэл нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Монгол мал хөтөлбөр”, “Хоршоог хөгжүүлэх хөтөлбөр”, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-тэй нийцүүлэн төслийн үйл ажиллагааг малчин өрхүүд, аймаг болон сумын төвийн иргэдийн дунд хэрэгжүүлж, жижиг дунд үйлдвэр, хоршоог дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, нэмүү өртгийг бий болгоход оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх Олон улсын сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт” төслийг Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сард соёрхон баталж, төслийн үйл ажиллагаа 2018 оны 5 дугаар сараас эхлэн Архангай, Өвөрхангай, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод зэрэг 6 аймгийн 24 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тус төсөл нь 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн 1: Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

Бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах, чадавхжуулах, малчдын бүлэгийн хуримтлалын санг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад чиглэсэн хөрөнгө оруулалт (эрсдэлийн сан, мал үржлийн дэмжлэг)-ыг сумын түвшинд хийх, бэлчээрийн хяналт үнэлгээ, фотомониторинг хийх,

Бүрэлдэхүүн 2: Зах зээлийн хөгжил

Эмэгтэйчүүд давамгайлсан бүлэг байгуулах, бизнесийг дэмжих, чадавх бэхжүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн батлан даалтанд хамруулах, ажлын байр засварлах, бичил, хөдөө аж ахуйн жижиг нэгжүүдийг дэмжих, зах зээлийг тэлэх, зах зээлд нэвтрэх үйл ажиллагаа, малчдын бүлгийн хуримтлалын санг хадгаламж, зээлийн хоршоотой холбох,

Бүрэлдэхүүн 3: Бизнесийн орчинг сайжруулах, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх

Сүү, жимс, жимсгэнэ, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний хөгжлийг дэмжих, төслийн орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг тодорхойлох, хөрөнгө оруулалт хийх, зах зээлд нэвтрэх, тэлэхэд нь дэмжлэг үзүүлэх, брэнд бүтээгдэхүүний зах зээлийн орчинг сайжруулах, бичил, жижиг бизнес эрхлэгчдийн батлан даалттай зээлд хамруулах,

Тайлант хугацаанд хийгдсэн ажлын талаар: “Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” бүрэлдэхүүн 1-ийн хүрээнд 2019 оны тайлант жилд сургалт, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа, тэр дундаа төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд бүрэн хэрэгжиж дууссан байна.

Төрийн бус байгууллага болон ТУН-ээс мэргэшсэн байгууллагуудтай гэрээ байгуулан зохион байгуулсан сургалт семинар, үзэсгэлэн худалдаа, туршлага судлах үйл ажиллагаануудад давхардсан тоогоор нийт 4600 гаруй иргэд хамрагдсан байна. Бичил, жижиг бизнес эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих үүднээс орон нутгийн болон үндэсний үзэсгэлэн худалдаанд хамруулахад дэмжлэг үзүүлж нийт 140 гаруй иргэдийг хамруулсан. Орон нутгийн бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалт, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх

үүднээс ажлын байр, борлуулалтын цэгийг засварлах ажлыг 14 суманд хийхээр төлөвлөж ажлыг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

“Зах зээлийн хөгжил” бүрэлдэхүүн 2-ын хүрээнд хийгдэх гол үйл ажиллагаа болох бичил бизнес эрхлэгчид буюу эмэгтэйчүүдийн бүлэг, хөдөө ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд аж ахуйн нэгж, хоршоодын бизнес төлөвлөгөөг санхүүжүүлэх батлан даалт бүхий зээл олгох ажил хэрэгжээгүй болно.

“Бизнесийн орчинг сайжруулах, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх” бүрэлдэхүүн 3-ын хүрээнд үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, тус бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд сүү цагаан идээ, хүнсний ногоо, жимс жимсгэний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд нь бүрэлдэхүүн 2-ын хүрээнд хийгдэх ажилтай давхардаж байгаа гэж төслийн санхүүжүүлэгч ХААХОУС- аас үзэж уг бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг “Зах зээлийн хөгжил” бүрэлдэхүүн 2-ын хүрээнд хэрэгжүүлэхээр болсон байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус төслийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Accolous” програм хангамж ашигладаг байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,215,513.7 мянган төгрөгөөс тооцон 24,310.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 113,778.6 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны нийт зардал 5,688,929.1 мянган төгрөг байсантай холбоотой.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 715,362.5 мянган төгрөгөөр буюу 92.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, Засгийн газрын оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,878,628.4	8,483,664.6	2,605,036.2
Авлага	3,491,075.2	27,658.5	(3,463,416.7)
Бараа материал	6,191.5	6,191.5	-
Үндсэн хөрөнгө	590,780.5	733,798.5	143,018.0
Нийт хөрөнгө	9,966,675.6	9,251,313.1	(715,362.5)
Өр төлбөр	3,380,170.0	3,722,651.5	342,481.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,586,505.6	5,528,661.6	(1,057,844.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,966,675.6	9,251,313.1	(715,362.5)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,605,036.2 мянган төгрөгөөр өссөн нь төслийн зээлийн батлан даалтын сангийн 3,475,348.1 мянган төгрөгийг 2018 оны 12 дугаар сарын 31-нд Төрийн сан улсын төсөвт татан төвлөрүүлж, 2019 онд буцаан шилжүүлсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 3,463,416.7 мянган төгрөгөөр буурсан нь зээлийн батлан даалтын сангийн дансанд байршсан дээр дурьдсан 3,475,348.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснийг Төрийн сангаас буцаан шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь төслийн хэрэгцээнд 178,400.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 2,866.5 мянган төгрөгийн компьютер, 2,652.6 мянган төгрөгийн оффисийн ширээ худалдаж авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь төслийн хүрээнд хийгдсэн 5 байгууллагын гэрээт ажлын төлбөр 344,786.9 мянган төгрөг тайлант ондоо төлөгдөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,528,661.6 мянган төгрөг болж 1,057,844.0 мянган төгрөгөөр буурсан нь 1,951,833.0 мянган төгрөгийн санхүүжилтийг санхүүжүүлэгч ХААХОУС-гаас нөхөн дүүргэлт тайлант ондоо хийгээгүйтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил үйлчилгээ хөтөлбөр, төслийн дотоод урсгал зардал гэсэн хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд

зориулан 5,792,778.6 мянган төгрөгийн төсөв, үүнээс 4,004,378.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,788,400.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт батлагдсан 5,792,778.6 мянган төгрөгийн төсвийн 5,473,658.6 мянган төгрөгийг Нэгдсэн үндэсний байгууллагын ХААХОУС-гийн хөнгөлөлттэй зээлээр, 319,120.0 мянган төгрөгийг Монгол Улсын Засгийн газар буюу улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

Зах зээл бэлчээрийн удирдлагын төсөл нь тайлант онд НҮБ-ын ХААХОУС-гийн хөнгөлөлттэй зээлээр 3,904,241.6 мянган төгрөг, улсын төсвөөс 319,120.0 мянган төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлогоос 92,374.4 мянган төгрөг нийт 4,315,736.0 мянган төгрөгийн орлого олж 5,309,636.4 мянган төгрөгийн зарцуулалт хийгджээ.

Улсын төсвөөс баталсан 319,120.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 310,197.1 мянган төгрөгийг зарцуулж, 8,922.8 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. ХААХОУС-ийн хөнгөлөлттэй зээлээс 5,473,658.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төсөвлөснөөс 4,077,564.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардалд 4,004,378.6 мянган төгрөгийг төсөвлөснөөс 3,628,346.6 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 376,031.9 мянган төгрөгийн зарцуулалт хийгдээгүй байна. Энэ нь төслийн дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний гэрээт ажил он дамжиж хийгдсэнээс 57,713.9 мянган төгрөг, нэмүү өртгийн сүлжээний зөвлөхийн гэрээ хугацаанаас өмнө дуусгавар болсноос 34,598.2 мянган төгрөг, санхүүжүүлэгч байгууллагын зөвлөмжийн дагуу “Бизнесийн орчинг сайжруулах, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төслийн сонгогдсон аж ахуйн нэгжүүдэд олгохоор төлөвлөж байсан тоног төхөөрөмж болон нэмүү өртгийн сүлжээний зах зээлийн брэнд бүтээгдэхүүний судалгааны ажлууд тайлант онд хийгдээгүйгээс 283,719.8 мянган төгрөгийн ажлуудын төлбөр тус тус хийгдээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгийн зардалд 1,788,400.0 мянган төгрөг төлөвлөгдснөөс бэлчээрийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд инженерийн хийцтэй худаг шинээр гаргах гэрээт ажлын төлбөр тайлант хугацаанд хийгдээгүйгээс 484,439.3 мянган төгрөгийн төсөвлөсөн зардал хэмнэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,932,307.3 мянган төгрөг буюу 85 хувьтай байгаа нь төлөвлөгдсөн ажлууд хийгдээгүй мөн гэрээт ажлын төлбөр бүрэн төлөгдөөгүйгээс шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр

Аудитыг төлөвлөх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 71,665.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 71,665.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 26/20 албан бичгээр аудитын байгууллагад ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.9.1-д “Төсвийн захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Дээрх зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Гэрээт ажлуудын төлбөр тооцоог цаг хугацаандаа хийгээгүй өглөгтэй байгаа асуудлыг нягтлах

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 77 мэдээллийг хугацаанд нь, 48 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 61.9 мянган төгрөгийн зөрчилд нийт 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй дүгнэлт”

Залруулагдаагүй 71,665.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 113,778.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Зээлийн батлан даалтын сангаас буцаан төвлөрүүлсэн 3,438,806.7 мянган төгрөгөөс валютын ханшийн зөрүүгийн олз болох 61,206.7 мянган төгрөгийг бүртгээгүй нь “Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө” УСНББОУС 4-ийн 33 дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна. -

3.1.2 Эрсдэл:

Ханшийн зөрүүгийн олзыг бүртгээгүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд стандартын дагуу залруулга хийх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

УСНББОУС 4-ийн 33 дахь заалтыг мөрдөж ажиллана.

3.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 6,061.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС 17-Үндсэн хөрөнгийн тодорхойлолт 13 (б) “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хөрөнгө дутагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн дансанд залруулан бүртгэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Санхүү байдлын тайланд хувь хүний орлогын албан татварын авлага 4,702.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан боловч татварын тайлангийн тодорхойлолтоос 4.397.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн" 5 дугаар зүйлийн 5.1.4-т зааснаар "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Тайлан тооцоо буруу илэрхийлэгдэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн үлдэгдэл тооцоог тухай бүр нь баталгаажуулж тайлан тооцоог үнэн зөв гаргаж байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,375,895,157.16</u>	<u>8,517,514,556.14</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,878,628,422.06	8,483,664,614.58
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	8,569.00	1,909.16
31110	Төгрөг	8,569.00	1,909.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,878,619,853.06	8,483,662,705.42
3121	Төгрөг	1,156,917,760.79	4,606,424,133.15
31211	Төрийн сангийн харилцах	1,156,917,760.79	4,606,424,133.15
3122	Гадаад валют	4,721,702,092.27	3,877,238,572.27
31223	Арилжааны банк дахь харилцах	4,721,702,092.27	3,877,238,572.27
33	АВЛАГА	3,491,075,255.10	27,658,461.56
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	18,090.00	31,814.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,475,348,075.10	00.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	00.00	4,702,059.56
335	Бусад авлага	15,709,090.00	22,924,588.00
3351	Байгууллагаас авах авлага	15,709,090.00	22,924,588.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,191,480.00	6,191,480.00
354	Хангамжийн материал	6,191,480.00	6,191,480.00
35420	Аж ахуйн материал	5,791,680.00	5,791,680.00
35470	Бусад хангамжийн материал	399,800.00	399,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>590,780,490.77</u>	<u>733,798,536.95</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	590,780,490.77	733,798,536.95
392	Биет хөрөнгө	590,780,490.77	733,798,536.95
39203	Авто-тээврийн хэрэгсэл	244,500,000.00	422,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(109,995,833.38)	(122,220,833.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	202,662,910.00	205,529,440.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,369,539.48)	(46,860,147.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,126,004.00	86,778,604.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,793,050.37)	(9,978,525.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	197,650,000.00	197,650,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,966,675,647.93</u>	<u>9,251,313,093.09</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,380,170,016.21</u>	<u>3,722,651,535.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,380,170,016.21	3,722,651,535.00
413	Өглөг	2,570,016.21	345,051,535.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,245,565.21	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	12,120,290.00

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4136	Бусад өглөг	1,324,451.00	332,931,245.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	332,666,637.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,324,451.00	264,608.00
414	Урьдчилж орсон орлого	3,377,600,000.00	3,377,600,000.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3,377,600,000.00	3,377,600,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,586,505,631.72	5,528,661,558.09
51	Засгийн газрын хувь оролцоо	6,586,505,631.72	5,528,661,558.09
512	Хуримтлагдсан үр дүн	6,586,505,631.72	5,528,661,558.09
51210	Өмнөх үеийн үр дүн	6,586,505,631.72	6,586,505,631.72
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(1,057,844,073.63)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,966,675,647.93	9,251,313,093.09

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,062,748,898.74	4,507,707,807.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,062,748,898.74	4,188,587,807.88
120	Нийтлэг татварын бус орлого	4,959,341,863.41	4,188,587,807.88
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,939,862,834.31	4,185,669,854.88
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	397,029,116.42	281,428,209.24
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,542,833,717.89	3,904,241,645.64
1200047	Батлан даалтын шимтгэлийн орлого	19,479,029.10	00.00
120009	Бусад орлого	00.00	2,917,953.00
122	Тусламжийн орлого	102,895,519.19	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	102,895,519.19	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	319,120,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	319,120,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	319,120,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	511,516.14	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	511,516.14	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,215,513,712.38	5,688,929,072.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,207,359,676.38	4,151,365,063.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,207,359,676.38	3,774,035,997.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,641,998.00	898,274,833.00
210101	Үндсэн цалин	561,641,998.00	898,274,833.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,896,843.31	110,679,883.00
210201	Тэтгэврийн даатгал	44,825,403.28	76,513,360.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,603,175.66	8,982,748.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,482,540.33	7,186,198.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,077,737.94	1,636,143.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,907,986.10	16,361,434.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	78,276,786.02
210301	Гэрэл, цахилгаан	00.00	195,799.99
210303	Цэвэр, бохир ус	00.00	36,186.48
210304	Байрны түрээс	00.00	78,044,799.55
2104	Хангамж, бараа материалын зардал	25,626,845.16	27,252,756.51
210401	Бичиг хэрэг	8,210,793.00	5,052,803.00
210402	Тээвэр, шатахуун	13,144,865.00	8,868,272.89
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,271,187.16	4,130,817.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	9,200,863.00
2107	Томилолт, зочны зардал	5,680,000.00	29,929,750.00
210702	Дотоод албан томилолт	5,680,000.00	29,929,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	532,583,058.54	2,121,840,043.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	532,583,058.54	2,121,840,043.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,930,931.37	507,781,945.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	466,880,861.29
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,930,931.37	40,901,083.82

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	377,329,066.42
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	377,329,066.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,922,847.44
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,154,036.00	1,537,564,009.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,154,036.00	1,537,564,009.00
220001	Барилга байгууламж	00.00	896,568,250.00
221001	Их засвар	00.00	456,692,492.00
222001	Тоног төхөөрөмж	8,154,036.00	184,303,267.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,847,235,186.36	(1,181,221,264.88)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	333,976,530.41	162,284,229.35
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	00.00	162,284,229.35
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	333,976,530.41	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,836,806.21	38,907,038.10
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	3,836,806.21	38,907,038.10
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	330,139,724.20	123,377,191.25
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,177,374,910.56	(1,057,844,073.63)

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	2,409,130,721.16	2,409,130,721.16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	2,409,130,721.16	2,409,130,721.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,177,374,910.56	4,177,374,910.56
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	6,586,505,631.72	6,586,505,631.72
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	6,586,505,631.72	6,586,505,631.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	6,586,505,631.72	6,586,505,631.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(1,057,844,073.63)	(1,057,844,073.63)
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	5,528,661,558.09	5,528,661,558.09

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,600,447,418.42	7,791,295,419.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,600,447,418.42	3,996,827,344.16
120	Нийтлэг татварын бус орлого	5,600,447,418.42	3,996,827,344.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,497,551,899.23	3,996,616,069.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	335,241,778.53	92,374,423.52
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,542,833,717.89	3,904,241,645.64
120009	Бусад орлого	619,476,402.81	211,275.00
122	Тусламжийн орлого	102,895,519.19	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	102,895,519.19	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	3,794,468,075.10
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	3,794,468,075.10
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	319,120,000.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,475,348,075.10
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,662,847,686.51	4,005,675,700.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,662,847,686.51	4,005,675,700.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,187,499,611.41	3,628,346,634.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,582,166.99	00.00
210101	Үндсэн цалин	419,582,166.99	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,369,299.50	00.00
210201	Тэтгэврийн даатгал	67,369,299.50	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	71,857,078.19
210301	Гэрэл, цахилгаан	00.00	178,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	32,896.80
210304	Байрны түрээс	00.00	71,646,181.39
2104	Хангамж, бараа материалын зардал	23,309,891.00	25,650,160.62
210401	Бичиг хэрэг	7,857,716.00	4,970,401.00
210402	Тээвэр, шатахуун	11,302,960.00	7,933,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,149,215.00	4,008,838.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	8,737,021.00
2107	Томилолт, зочны зардал	5,680,000.00	29,929,750.00
210702	Дотоод албан томилолт	5,680,000.00	29,929,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	671,558,253.92	3,034,028,784.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	671,558,253.92	3,034,028,784.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	466,880,861.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	466,880,861.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,475,348,075.10	377,329,066.42
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт,	3,475,348,075.10	377,329,066.42

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,475,348,075.10	8,922,847.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,475,348,075.10</u>	<u>3,785,619,718.27</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>937,599,731.91</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	413,312,270.00	1,303,960,717.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	413,312,270.00	1,303,960,717.00
2200	Дотоод эх үүсвэрээр	413,312,270.00	1,303,960,717.00
220001	Барилга байгууламж	00.00	577,010,025.00
221001	Их засвар	00.00	396,615,584.00
222001	Тоног төхөөрөмж	413,312,270.00	330,335,108.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(413,312,270.00)</u>	<u>(1,303,960,717.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>333,976,530.41</u>	<u>00.00</u>
14	Бусад эх үүсвэр	00.00	162,284,229.35
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	333,976,530.41	38,907,038.10
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	333,976,530.41	38,907,038.10
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	<u>123,377,191.25</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	858,263,992.32	2,605,036,192.52
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,020,364,429.74	5,878,628,422.06
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,878,628,422.06	8,483,664,614.58

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,792,778,600.00	4,932,307,351.57	(860,471,248.43)	85.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,004,378,600.00	3,628,346,634.57	(376,031,965.43)	90.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,004,378,600.00	3,628,346,634.57	(376,031,965.43)	90.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,753,000.00	71,857,078.19	(6,895,921.81)	91.2
210301	Гэрэл, цахилгаан	178,000.00	178,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	63,000.00	32,896.80	(30,103.20)	52.2
210304	Байрны түрээс	78,512,000.00	71,646,181.39	(6,865,818.61)	91.3
2104	Хангамж, бараа материалын зардал	44,059,000.00	25,650,160.62	(18,408,839.38)	58.2
210401	Бичиг хэрэг	6,442,000.00	4,970,401.00	(1,471,599.00)	77.2
210402	Тээвэр, шатахуун	18,432,000.00	7,933,900.00	(10,498,100.00)	43.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,185,000.00	4,008,838.62	(6,176,161.38)	39.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,000,000.00	8,737,021.00	(262,979.00)	97.1
2107	Томилолт, зочны зардал	36,000,000.00	29,929,750.00	(6,070,250.00)	83.1
210702	Дотоод албан томилолт	36,000,000.00	29,929,750.00	(6,070,250.00)	83.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,845,566,600.00	3,500,909,645.76	(344,656,954.24)	91.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,845,566,600.00	3,500,909,645.76	(344,656,954.24)	91.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	-	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,788,400,000.00	1,303,960,717.00	(484,439,283.00)	72.9
2200	Дотоод эх үүсвэрээр	1,788,400,000.00	1,303,960,717.00	(484,439,283.00)	72.9
220001	Барилга байгууламж	1,040,000,000.00	577,010,025.00	(462,989,975.00)	55.5
221001	Их засвар	417,600,000.00	396,615,584.00	(20,984,416.00)	95.0
222001	Тоног төхөөрөмж	330,800,000.00	330,335,108.00	(464,892.00)	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,792,778,600.00	4,214,438,798.20	(1,314,758,301.49)	77.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	319,120.000	310,197,152.56	8,922,847.44	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	319,120.000	310,197,152.56	8,922,847.44	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,473,658,600	3,904,241,645.64	(1,569,416,954.36)	71.3

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,473,658,600	3,904,241,645.64	(1,569,416,954.36)	71.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	54	54	-	
620001	Удирдах ажилтан	2	2	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	50	50	-	
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	
620004	Гэрээт ажилтан				

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.19	Аудитын нэр:	2019 оны Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл			САГ-2020/725/СТА-ТХН	мянган төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг дагаж мөрдөөгүй санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2020 оны 02 сарын 27-ны өдрийн 26/20 албан бичгийн хамт аудитын байгууллагад ирүүлсэн.	-	Албан шаардлага хүргүүлэх	Төслийн зохицуулагч	С.Занданбал
Зээлийн батлан даалтын сангаас буцаан төвлөрүүлсэн 3,438,806.7 мянган төгрөгөөс валютын ханшийн зөрүүгийн олз болох 61,206.7 мянган төгрөгийн олзыг салгаж бүртгээгүй байгаа нь УСНББОУС 4.33 заалттай нийцэхгүй, иж бүрэн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.	61,206.7	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Б.Уламбаяр
Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 6,061.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС 17-Үндсэн хөрөнгийн тодорхойлолт 13 (б) "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	6,061.5	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Б.Уламбаяр
Санхүүгийн тайланд тусгагдсан татварын үлдэгдлийн дүнг татварын тодорхойлолттой тулган шалгахад хувь хүний орлогын албан татварын авлагын дүн 4,397.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагджээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т зааснаар "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.	4,397.7	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Б.Уламбаяр
Дүн	71,665.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 02/163

Улаанбаатар хот

САГ- 2020/725/СТА-ТХН

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтыг зөрчин 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 26/20 тоот албан бичгээр санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын байгууллагад ирүүлсэн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх..” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны 95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д” алдаа зөрчилд Төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ажилтнуудад сахилгын хариуцлага тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зохицуулагч С.Занданбал, нягтлан бодогч Б.Уламбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Ч.ДАШДАВАА

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ч.ГҮНДБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН
УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ

С.ЗАНДАНБАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.УЛАМБАЯР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ

A series of 28 horizontal dotted lines for writing.